

Германы Бундестагийн
тогтоолын үндсэн дээр
хөхиүлэн дэмжсэн:



Холбооны
Хүнс,
хөдөө аж ахуйн яам



ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний үзэл баримтлал, чиг үүрэг, цаашдын хөгжлийн асуудлууд

Б.Эрдэнэболор, PhD

Хэрэгжүүлэгч байгууллагууд



Түши байгууллага



ГАРЧИГ

1. ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний тодорхойлолт, ач холбогдол
2. Нэвтрүүлэх үйлчилгээний чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлүүд
3. Хөгжлийн чиг хандлага, олон улсын туршлага
4. Монгол улсад ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээг бэхжүүлэх санал, зөвлөмж

1. Нэвтрүүлэх үйлчилгээний тодорхойлолт, ач холбогдол



Зургийн эх сурвалж: Зохиогч



Тодорхойлолт

Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх (экстейншний) үйлчилгээ гэж

- ХАА-н үйлдвэрлэлийн технологи, менежментийг сайжруулах,
- Үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх,
- Үйлдвэрлэл эрхлэгчдийг салбарын бусад оролцогч талуудтай болон зах зээлд холбоход

чиглэсэн оюуны ба зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хэлнэ.

Эх сурвалж: Cristoplos, (2010), өөрчлөн ашиглав.



Нэвтрүүлэх үйлчилгээний эдийн засгийн үр өгөөж

1. Нэвтрүүлэх үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө оруулалтын өгөөж – Return on Investment*:

- Хөгжиж буй орнуудад 15%-200%, дунджаар 80%
- Өндөр хөгжилтэй орнуудын төлөөлөл АНУ-д 16%-110%
- Хөгжиж буй болон хөгжсөн 100 орны дунджаар 58%

2. Эдийн засгийн бусад ач холбогдол:

- **Ядуурлыг бууруулах:** Этиоп улсад хийгдсэн судалгаанаас үзвэл фермерүүдийг жилд нэг удаа зөвлөх үйлчилгээнд хамруулах нь ядуурлыг 10%-иар бууруулдаг байна.
- **ХАА-н үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх:** АНУ-д ХАА-н үйлдвэрлэлийн бүтээмж нэвтрүүлэх үйлчилгээний үр дүнд 1949-2002 онд 7.3%-иар нэмэгдүүлжээ.
- **ХАА-н эрдэм шинжилгээнд зарцуулсан хөрөнгө оруулалтын үр дүнг нэмэгдүүлэх.**

Эх сурвалж: Alston *et al.*, 2000; Huffmann ба Evenson, 2006; Dercon *et al.*, 2008, Alston *et al.* 2011.

Нэвтрүүлэх үйлчилгээний ангилал

1. Ганцаарчилсан үйлчилгээ

- Мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ, зуучлал, гэрээт зөвлөх
- Ганцаарчилсан сургалт (шавь сургалт)

2. Бүлгийн нэвтрүүлэх үйлчилгээ

- Сургалт
- Сургалт-үйлдвэрлэлийн төсөл
- Талбайн өдөрлөг, үзүүлэх сургалт
- Бүлэг, хоршоодын гэрээт зөвлөх үйлчилгээ, зуучлал
- Мэдээлэл, туршлага солилцох уулзалт, арга хэмжээнүүд

3. Масст чиглэсэн нэвтрүүлэх үйлчилгээ

- Харилцааны ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан мэдээлэл түгээх, зайны сургалт явуулах
- Сурталчилгааны плакат, самбар ашиглах
- Нийтийг хамарсан кампанит ажил

Нэвтрүүлэх үйлчилгээнд баримтлах зарчмууд

- **Эрэлтэд нийцсэн үйлчилгээ:** Малчид, тариаланчдын эрэлт хэрэгцээг тодорхойлж, бодит хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ, сургалт, мэдээллийн ажлуудыг зохион байгуулах
- **Оролцоонд суурилсан үйлчилгээ:** Малчид, тариаланчдын оролцоог идэвхжүүлэх. Бэлэн санаа, зөвлөмж хэлж өгөхөөс илүүтэйгээр өөрсдөө бие даан санаачилга гаргаж, хэрэгжүүлэх үйл явцыг идэвхжүүлэх. “Багшгүй сургалт” буюу туршлага солилцоо, бие даан суралцах үйл явцыг идэвхжүүлж, чиглүүлэх.
- **Практикт ойр байх:** Сургалтыг үйлдвэрлэлийн нөхцөлд зохион байгуулах. Гарын авлага материалыг малчид, тариаланчдад ойлгомжтой энгийн үг хэллэгтэй, ойлгоход хялбар хэлбэрээр бэлтгэх.
- **Эргэх холбоо:** Үйлчилгээний хүртээмж, үр дүн, үр нөлөөг хянаж байх, малчид тариаланчдаас санал хүсэлтийг нь тогтмол авч байх суваг, хэрэгслийг бүрдүүлэх. Жишээлбэл: Ногоон алт төслийн Аяны богцны туршлагаас нэвтрүүлэх.

2. Чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлүүд

1. Сургалт, мэдээлэл, зөвлөх үйлчилгээ

- ХАА-н үйлдвэрлэлийн технологийн
- Эдийн засаг, бизнесийн
- Хувь хүний болон бүлэг, хоршоодын хөгжлийг дэмжих чиглэлээр сургалт, мэдээллийн ба зөвлөх үйлчилгээ үзүүлэх.

2. Инновацийн зуучлал

- Шинэ мэдлэг, шинэлэг бүтээгдэхүүн, арга, технологиудыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх.

3. Зах зээлийн холболт

- Үйлдвэрлэлийн орц ба зээлийн хангамж
- Бүтээгдэхүүний хадгалалт, боловсруулалт, борлуулалтыг сайжруулах үйл явцыг идэвхжүүлэх.

4. Мэдээлэл, туршлага солилцоо

- ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд хоорондоо мэдээлэл, мэдлэг, туршлагаа солилцох боломжийг нь бүрдүүлэх, уг үйл явцыг идэвхжүүлэх.

Сургалт, мэдээлэл, зөвлөх үйлчилгээ

- **Сургалт:** Технологи, менежмент ба зохион байгуулах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр танхимын, талбайн ба үзүүлэх сургалт зохион байгуулах.
- **Мэдээллийн үйлчилгээ:** Хэрэгцээтэй мэдээллийг төрөл бүрийн эх үүсвэрээс олж, зорилтот бүлэгтээ ойлгомжтой хэлбэрт оруулан боловсруулж, түгээх.
- **Зөвлөх үйлчилгээ:** Зорилтот бүлэгт тулгамдсан бэрхшээлийг шинжилж, учир шалтгаан, үр дагаврыг нь таниулах, шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, бодит шийдлүүдийг боловсруулах.

Анхаарах зүйл:

Бусдад тулгарсан бэрхшээлийг өмнөөс нь бүү шийдвэрлэ!

Нэвтрүүлэх үйлчилгээ нь зорилтот бүлэгтээ бие даан бэрхшээлээ шийдвэрлэх мэдлэг, ур чадвар, эрмэлзлийг бий болгох зорилготой болохоос бусдын асуудлыг өмнүүр нь орж шийдвэрлэх үүрэггүй.

Төлбөртэй сургалт, мэдээллийн үйлчилгээ

Төлбөртэй сургалт

- Орон нутгийн телевизийн сувагтай хамтран ажиллаж, сургалтаа сурталчлах
- Тодорхой сэдвүүдээр брэнд сургалтуудтай болох
- Шилдэг мэргэжилтнүүдийг багшлуулах
- Оролцогчдод нэмэлт (бонус) үйлчилгээ санал болгох: жишээ нь сургалтын аялал, үзэсгэлэнд оролцуулах, олонд танигдсан мэргэжилтэнтэй уулзуулах г.м.

Төлбөртэй мэдээллийн үйлчилгээ

- Гарын авлага, богино хэмжээний материал (технологийн карт, хүнсний ногооны зоорь, малын байрны зураг төсөл г.м.) бэлтгэж, худалдах
- Мэдээллийн уулзалт, форум, бусад арга хэмжээ зохион байгуулж, оролцогчдоос хураамж авах

Төлбөртэй зөвлөх үйлчилгээ

1. Гэрээт зөвлөхийн үйлчилгээ

- ХАА-н үйлдвэрлэл эрхэлдэг ААН буюу үйлдвэрлэгчдийн байгууллага (бүлэг, хоршоо, нийгэмлэг, холбоо г.м.)-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, тодорхой хугацаанд, тодорхой чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгнө.
- Зөвлөх үйлчилгээний хөлсийг тооцохдоо нийт ажлыг цаг буюу хоногоор хэмжиж, цаг, хоногоор тогтоосон тарифаар үнэлнэ. Мөн үнийн дүнгийн тодорхой хувийг үр дүнгээс хамаарах урамшуулал байдлаар тогтоож болно. Энэ тохиолдолд хэрэв зөвлөх үйлчилгээний үр дүнд харилцагчийн ашиг төлөвлөснөөс давбал зөвлөхийн урамшуулал мөн нэмэгдэнэ.

2. Туслан гүйцэтгэх зөвлөх үйлчилгээ

- Бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхэд зөвлөх үйлчилгээний байгууллага туслан гүйцэтгэгчээр оролцоно. Жишээлбэл шинээр малын ферм барих ажлыг барилгын компани гүйцэтгэхэд ХАА-н зөвлөх үйлчилгээний компани мэргэжлийн зөвлөгөө өгөх байдлаар хавсран оролцож болно.

Инновацийн зуучлал

Инноваци гэж юу вэ?

- Аливаа хувь хүмүүс буюу байгууллагууд өөрсдийнх нь хувьд шинэлэг бараа, үйлчилгээг бүтээх, үйлдвэрлэх үйл явц (Дэлхийн банк, 2006).
- Технологийн инноваци, менежмент, зохион байгуулалтын инноваци г.м. бүх чиглэлийг хамарна.

Инновацийн зуучлал

- ХАА-н үйлдвэрлэгчдэд ашигтай шинэ арга, технологи, бүтээгдэхүүнийг санал болгох, эрдэм шинжилгээ, инновацийн байгууллагуудтай холбох.
- ХАА-н үйлдвэрлэгчид өөрсдөө үйлдвэрлэлийн нөхцөлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, арга, технологи бий болгох явцыг дэмжих, чиглүүлэх.
- Шинэ технологи нутагшуулах чиглэлээр төсөл санаачилж, дотоод гадаадын эх үүсвэрийн буюу хувийн хэвшлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх

Зах зээлийн холболт

Үйлдвэрлэлийн орц, материалын хангамжийг сайжруулах

- Үйлдвэрлэлийн орц, материалыг их хэмжээгээр, үнийг нь бууруулж авах ажлыг нутгийн ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд болон нэвтрүүлэх үйлчилгээний алба, нэгжид аль алинд ашигтай байдлаар зохион байгуулах.
- Дотоодод буюу ойролцоох улс орнуудад тоног төхөөрөмжийн үзэсгэлэн гарах үеэр аялал зохион байгуулах.
- Нутгийн ХАА-н үйлдвэрлэгчдэд хэрэгцээтэй үйлдвэрлэлийн орц материал, тоног төхөөрөмж нийлүүлэгчидтэй хамтран ажиллаж, борлуулалтад нь туслах, тухайлбал бүтээгдэхүүнийг нь танилцуулж сурталчлах, туршилт, үзүүлэх сургалт зохион байгуулах г.м.

Зах зээлийн холболт

Зээлийн хүртээмжийг сайжруулах

- Харилцагчдад зээл авах боломж, нөхцлүүдийн талаар мэдээлэл олгох, зээлийн төсөл боловсруулах ур чадвар эзэмшүүлэх, зээлийн төслийг нь боловсруулж өгөх, барьцааны хөрөнгөө болон хүссэн зээлийнхээ хэмжээг бодитоор үнэлэхэд нь туслах, авсан зээлийг үр дүнтэй зарцуулахад нь туслах, төсөв төлөвлөгөө боловсруулж өгөх.
- Нэвтрүүлэх үйлчилгээ хариуцсан ажилтан, зөвлөхүүд i) өөрсдөө зээлийн нөхцлүүдийг сайтар судалж мэдэх, ii) харилцагчдынхаа төлбөрийн чадварын талаар тэдэнтэй сайтар зөвлөлдөх, iii) харилцагчиддаа зээл авах талаар бодитой төлөвлөгөө, шийдвэр гаргахад нь туслахад анхаарвал зохино.
- Зээл олгодог банк, санхүүгийн байгууллагуудыг тухайн орон нутгийн зах зээл, үйлдвэрлэлийн талаар мэдээллээр хангах, ХАА-н бизнесийн эрсдэлийн үнэлгээ хийхэд нь туслах.

Зах зээлийн холболт

Бүтээгдэхүүний хадгалалт, боловсруулалтыг сайжруулах

- ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийг боловсруулах үйлдвэрүүдтэй холбох, орон нутагт шинээр агуулах, зоорь барих асуудлыг шийдвэр гаргах төвшинд тавьж шийдвэрлүүлэх, энэ чиглэлээр зээл, тусламж хөөцөлдөх зэргээр санаачилга гаргах, эсвэл нутгийн иргэдийн тодорхой санаачилгуудыг дэмжиж ажиллах.
- Орон нутагт зоорь, элеватор барих буюу боловсруулах үйлдвэрлэл эрхлэх чиглэлээр техник-эдийн засгийн бодит үндэслэлтэй төслүүд боловсруулж, хувийн хэвшлийн ААН-үүд, хөрөнгө оруулагчдад санал болгох.


Бүтээгдэхүүн, түүхий эдийн борлуулалтыг сайжруулах

1. ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд зах зээлийн тухай мэдлэг, мэдээлэл олгох, худалдан авагчидтай холбох, яармаг худалдаанд оролцуулах, бүтээгдэхүүний чанарын сертификат авахад туслах г.м.
2. Нэвтрүүлэх үйлчилгээний алба ХАА-н бүтээгдэхүүн, түүхий эдийн борлуулалтад хамааралтай бүхий л оролцогчидтой (тээвэрлэгчид, ченжүүд, боловсруулах үйлдвэрүүд, экспортлогчид г.м.) харилцаатай байх шаардлагатай.

Мэдээлэл, туршлага солилцоог ИДЭВХЖҮҮЛЭХ

- **Уулзалт, арга хэмжээнүүд:** Сум, багийн төвшинд олон нийтийн болон бүлгийн уулзалт, хэлэлцүүлэг, бусад арга хэмжээнүүд зохион байгуулах. Сум, багаас нэгэнт төлөвлөсөн арга хэмжээний хөтөлбөрт мэдээлэл, туршлага солилцох үйл ажиллагааг нэмж оруулах.
- **Сошл сувгуудаар идэвхжүүлэлт хийх:** Фэйсбүүк болон бусад сошл сүлжээнүүдэд ХАА-н үйлдвэрлэгчид хоорондоо мэдээлэл, туршлага солилцоход зориулсан сувгууд бий болгож, гишүүдийн идэвхтэй оролцоог хангах. Идэвхжүүлэлтэд санал асуулга, шагналт нийтлэл, фото зургийн уралдаан, орон нутгийн удирдлагууд, мэргэжилтнүүдтэй шууд ярилцлага зохион байгуулах зэрэг аргуудыг ашиглана. Сошл бүлэг буюу пэйж хуудас дээрээ бүтээгдэхүүний сурталчилгаа төлбөртэй байрлуулах замаар болзолт уралдааны шагнал урамшууллын төсвийг бүрдүүлж болно.
- **Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллах:** Тэргүүний малчид, тариаланч, фермерүүдийн туршлагыг түгээх, тодорхой сэдвээр нийтийг хамарсан хэлэлцүүлэг өрнүүлэхэд орон нутгийн сонин, телевиз, радиогийн сувгуудтай хамтран ажиллах.

Экстейншний эрвээхэй



Зургийн эх сурвалж: Katz, 2003

3. Нэвтрүүлэх үйлчилгээний хөгжлийн чиг хандлага, олон улсын туршлага



Зургийн эх сурвалж: Зохиогч

Нэвтрүүлэх үйлчилгээний засаглалын хэлбэрүүд

- ХАА-н яамны мэдэлд (ихэнхи хөгжиж буй орнуудад)
- Орон нутгийн захиргааны мэдэлд (БНХАУ, Энэтхэг, Япон, Индонез, Мексик, Филиппин)
- Төрийн өмчийн ХАА-н их сургуулиудын дэргэд (АНУ)
- ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийн хоршоо, нийгэмлэгүүдийн мэдэлд (Нидерланд, Дани, Их Британи, Шинэ Зеланд зэрэг өндөр хөгжсөн орнууд, Латин Америкийн зарим хөгжиж буй орнууд)
- Хувийн хэвшлийн ААН-үүдийн нэвтрүүлэх үйлчилгээ (дэлхий дахинд)


Олон улсын чиг хандлагаас үзвэл ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээг төрийн ба төрийн бус байгууллагууд, их дээд сургуулиуд, фермерийн хоршоо, нийгэмлэгүүд, хувийн хэвшлийн байгууллагууд зэрэгцэн буюу хамтран хэрэгжүүлдэг, санхүүжилтийг нь төр, хувийн хэвшил хамтран бүрдүүлдэг Олон оролцогч бүхий (“ПЛЮРАЛИСТ”) ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний тогтолцоо зонхилж байна.

Нэвтрүүлэх үйлчилгээг санхүүжүүлэх хувилбарууд

Гүйцэтгэгч	Санхүүгийн эх үүсвэр				
	Улс, орон нутгийн төсөв	ХАА-н үйлдвэрлэгчид	Хувийн хэвшлийн ААН-үүд	ТББ-ууд	Үйлдвэрлэгчдийн байгууллагууд
Төрд харъяалагдах экстейншний алба, нэгж	Төсвөөс бүрэн санхүүжих, төлбөргүй үйлчилгээ	Төрийн үйлчилгээний алба, нэгж гүйцэтгэх боловч үйлчилгээний төлбөр авна.		Төрийн үйлчилгээний алба, нэгж ТББ буюу ҮБ-д төлбөртэй захиалгат ажил гүйцэтгэнэ.	
Хувийн хэвшлийн байгууллага, ААН	Төсвөөс санхүүжих гэрээт ажил	1) Төлбөртэй зөвлөх үйлчилгээ, 2) Дагалдах үйлчилгээ: Боловсруулах үйлдвэрүүд болон борлуулалтын ААН-үүд харилцагчиддаа экстейншний үйлчилгээ үзүүлнэ.		Хувийн хэвшлийн зөвлөхүүд, зөвлөх үйлчилгээний компаниуд ТББ-д буюу ҮБ-ийн захиалгаар төлбөртэй ажил гүйцэтгэнэ. Төлбөрийг байгууллага төлж, гишүүд нь үнэгүй хамрагдана.	
Төрийн бус байгууллага	Төсвөөс санхүүжих гэрээт ажил	1) Төлбөртэй үйлчилгээ; 2) Нэг удаагийг хугацааны гэрээт зөвлөхийн үйлчилгээ			захиалгат ажил; 3) Урт, дунд
Үйлдвэрлэгчдийн байгууллага (ҮБ): бүлэг, хоршоо, холбоо, нийгэмлэг	Төсвөөс санхүүжих гэрээт ажил	ҮБ-ын зөвлөхүүдийг ажиллуулж, хөлсийг нь ХАА-н үйлдвэрлэгчид буюу хувийн хэвшлийн ААН төлнө.		ҮБ-ын зөвлөхийн хөлсийг ТББ төлнө.	ҮБ гишүүддээ үзүүлэх үйлчилгээг гишүүдийн татвар, бусад орлогоор санхүүжүүлнэ.

Нэвтрүүлэх үйлчилгээг олон эх үүсвэрээс санхүүжүүлэх жишээ

Австрали улсын ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний санхүүжилт, 2005–2015 он




Эх сурвалж: DAWR, 2017



Нэвтрүүлэх үйлчилгээний төсвийн санхүүжилт

Төсвийн эх үүсвэрийг голчлон ХАА-н бүтээгдэхүүний, борлуулалтын орлогоос тодорхой хувь хэмжээгээр шимтгэл авч бүрдүүлдэг.

Төсвийг нэвтрүүлэх үйлчилгээний байгууллагад (гүйцэтгэгчид) мөнгөн хэлбэрээр, эсвэл харилцагчдад нь (ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд) ваучерийн хэлбэрээр олгодог.



Их сургуулийн дэргэдэх нэвтрүүлэх үйлчилгээний жишээ: АНУ, Виржиниа муж улс


- 1906 онд анхны сургалт-үйлдвэрлэлийн төв байгуулагдсан.
- 1914 онд төрөөс төрийн өмчийн их сургуулиудад ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний төсөв олгож байх журам хэрэгжиж эхэлснээр Виржиниа мужийн төрийн өмчийн 2 их сургуулийн хамтарсан ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний төв байгуулагдан ажиллаж эхэлсэн.
- Сүүлийн жилүүдэдийн төсөв жилд 100 орчим сая ам.доллар. Холбооны болон муж улсын засгийн газраас цалин, урсгал зардал, орон нутгийн захиргаанаас үйл ажиллагааны төсөв олгодог.
- Нэвтрүүлэх үйлчилгээний чиглэлүүд:
 - Хөдөө аж ахуй, байгалийн нөөцийн менежмент
 - Хөдөөгийн хүүхэд, залуучуудын хөгжил
 - Гэр бүл, эрүүл мэнд, хүнсний зохистой хэрэглээ
 - Хамтын хөгжил ба амьдрах орчин
- Засаг захиргааны нэгжийн төвшинд фермерүүд ба засаг захиргааны төлөөллөөс бүрдэх “Зөвлөх багууд” ХАА-н Нэвтрүүлэх үйлчилгээний үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, ерөнхий удирдамжаар хангаж ажилладаг.

Виржиниа муж улс дахь ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний нэгжүүд

- ★ (star in circle) Виржиниагийн их сургууль, Виржиниагийн Политехникийн их сургууль
- ▲ (red triangle) Дүүргийн ХААНҮ хариуцсан оффисууд
- (black circle) ХААНҮ-ний нэгжийн оффисууд
- ◈ (green hexagon) ХАА-н эрдэм шинжилгээ, эксейншиний төвүүд (x11)

◆ (orange diamond) Судалгааны төвүүд (x2)

◻ (yellow square) 4Н Экстейншиний төвүүд (x6)




Эх сурвалж: www.ext.vt.edu



Орон нутгийн захиргааны хариуцсан нэвтрүүлэх үйлчилгээний жишээ: БНХАУ

- БНХАУ-ын ХАА-н Технологи Нэвтрүүлэх Үйлчилгээний тогтолцоо нь дэлхийн хамгийн том ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний тогтолцоонд тооцогддог.
- 800 мянган экстейншиний ажилтнууд 637 мянган багийн 200 гаруй сая тариачдад хүрч ажилладаг. 283 тариачин тутамд 1 зөвлөх ногдоно (хөгжиж буй орнуудын дунджаар 4000, өндөр хөгжсөн орнуудын дундаж 200).
- Төсвийг нь үндсэндээ төрөөс хариуцдаг боловч зөвлөхүүд мөн хувийн хэвшлийн компаниудтай гэрээ байгуулах, ХААТНТ-үүд зохиомол хээлтүүлэг, үр, бордоо борлуулах зэргээр нэмэлт орлого олдог. Ялангуяа жижиг фермерүүдийг дэмжиж ажилладаг, “Лууны толгой” статустай 60 мянган компани зөвлөхүүдийг гэрээгээр ажиллуулах нь түгээмэл.
- ХААТНТ-үүдийн үйл ажиллагааны чиглэлүүд:
 - Коммунист намын бодлогыг орон нутагт ухуулж сурталчлах
 - Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх
 - ХАА-н үйлдвэрлэл, бүтээмжийг нэмэгдүүлэх 5 жилийн төлөвлөгөөний биелэлтийг хангах
- Хятадын ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний тогтолцоо нь сүүлийн жилүүдэд төр, хувийн хэвшлийн холимог хэлбэрт амжилттай шилжиж байна.

БНХАУ-ын ХАА-н технологи нэвтрүүлэх үйлчилгээний бүтэц



Хувийн хэвшлийн нэвтрүүлэх үйлчилгээний жишээ: БНХАУ

- **Да Бэй Нон групп:** Агрохимийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч тус групп 27 мянган ажиллагсадтай, үүнээс 1000 орчим ЭША, 10 мянга гаруй экстейншиний ажилтантай. Нийт 60 гаруй үйлдвэрлэлийн нэгж, 80 гаруй охин компани, 2000 гаруй үйлчилгээний төвтэй. Фермерийн сургалт, зөвлөгөө өгч, хамтарсан талбайн туршилт судалгаа, үзүүлэх сургалт зохион байгуулдаг.
- **Nestle:** Сүү болон кофе үйлдвэрлэлийн чиглэлээр Хятадад ажилладаг Швейцарийн Nestle компани Шуанчень мужийн захиргаатай хамтран сүү үйлдвэрлэлийн сургалт, ЭШ-ний хүрээлэн, Юннан мужийн захиргаатай хамтран кофе сургалт, ЭШ-ний төв байгуулсан бөгөөд өөрийн нийлүүлэгч 20 гаруй мянган фермерийг сургаж, технологийн зөвлөгөө өгч хамтран ажилладаг.
- **Syngenta ба Crop Life:** Ургамал хамгааллын бодис үйлдвэрлэгч тус компаниуд фермерүүд болон мэргэжилтнүүдийн ургамал хамгааллын мэдлэгийг сайжруулах чиглэлээр ХААТНТ-үүдийг дэмжиж, санхүүжилт олгон хамтран ажилладаг.
- **Супермаркетууд:** Хятадын Засгийн газар “Шууд борлуулалт” хөтөлбөрийн хүрээнд бүтээгдэхүүнээ фермерүүдээс шууд татаж авч буй супермаркетуудыг тусгайлан дэмжиж буйтай холбоотойгоор супермаркетууд ХААТНТ-үүдтэй хамтран ажиллах санаачлага нэмэгдэж байна.

Хувийн хэвшлийн нэвтрүүлэх үйлчилгээний жишээ

- **Чили:** Чили улсын ХАА яам жил бүр хувийн хэвшлийн нэвтрүүлэх үйлчилгээний байгууллагуудад төсөв олгож, гэрээ байгуулан ажилладаг.
- **Шри Ланка:** Жимс, хүнсний ногоо экспортлогч HJS Condiments компанийн зөвлөхүүд нийлүүлэгч 8000 тариаланч тус бүртэй ургалтын сезоны үеэр 2 долоо хоног буюу сар тутам уулзаж, ургалтад хяналт тавьж, зөвлөгөө өгөх ба мөн сургалтанд хамруулдаг. 100 тариаланчид 1 зөвлөх ногддог. Зөвлөх үйлчилгээний зардлыг компани бүрэн хариуцдаг. Тус компани түүнчлэн тариаланчдад хөнгөлөлттэй зээл олгож, ургацаар нь нөхөн төлүүлдэг.
- **Кени:** Хүнсний ногоо экспортлогч Mase Foods компани 2004 онд USAID-тэй хамтран Нэвтрүүлэх үйлчилгээний төсөл 1 жил хэрэгжүүлсний дараа өөрийн зардлаар уг ажлыг гүйцэтгэх болжээ. Одоо тус компани 5000 тариаланчдыг 100 орчим бүлэгт зохион байгуулан бүлэг тус бүрт 1 зөвлөх ажиллуулж байна.
- **Энэтхэг:** ХАА-н Экстейншиний Менежментийн Хүрээлэн нь фермерүүдэд үйлдвэрийн орц нийлүүлэгч, борлуулагч компаниудын мэргэжилтнүүдэд жил бүр сургалт явуулж, фермерүүдэд технологийн зөвлөгөө өгөх онолын суурь, практик мэдлэг олгодог байна.

Үйлдвэрлэгчдийн хоршоо, нийгэмлэгүүдийн хариуцсан нэвтрүүлэх үйлчилгээний жишээ

- **Дани:** 3600 ажилтантай Данийн ХАА-н Зөвлөх үйлчилгээний төв нь үндэсний төвшний фермерүүдийн нийгэмлүүдийн шууд удирдлага дор ажилладаг бөгөөд нэг фермер дунджаар ажилд 10 мянган евроны хураамж төлдөг.
- **Франц:** Францын орон нутгийн ХАА-н танхимууд ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний 7000 ажилтантай бөгөөд үйлчилгээг фермерүүдээс хурааж авсан газрын татвараар санхүүжүүлдэг.
- **Энэтхэг:** Сүүний маркетингийн “Гужарат” холбоо 2.8 сая гишүүддээ сүү борлуулахад нь зуучлахаас гадна зохиомол хээлтүүлгийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.
- **Герман:** 1.4 гишүүнтэй Райффайзен хоршоодын сүлжээ нь гишүүддээ орц нийлүүлэх, зээл олгох, борлуулалтын зуучлал үзүүлэх зэрэг тал бүрээр дэмжихээс гадна 50 мянга гаруй зөвлөхүүд нь гишүүн бүртэйгээ тогтмол уулзаж технологийн зөвлөгөө өгөх, сургалтад хамруулах, үзүүлэх сургалт зохион байгуулах зэргээр нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлдэг.
- **Шинэ Зеланд:** Тус улсад төрөөс ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээнд шууд төсөв олгохоо зогсоосон боловч фермерийн холбоо, нийгэмлэгүүд борлуулалтын хураамжаар (levy) нэвтрүүлэх үйлчилгээг санхүүжүүлэн гүйцэтгэж байна.

Төрийн оролцоогүй нэвтрүүлэх үйлчилгээний сургамж

- **Англи:** Английн ХАА-н хөгжлийн зөвлөх үйлчилгээний төвийг 1987 онд хувьчилснаар уг төв нь консалтингийн үйлчилгээ эрхлэгч ХХК болон хувирсан ба зөвхөн томоохон фермерүүдэд үйлчлэх, төрийн болон хувийн хэвшлийн гэрээт ажил гүйцэтгэх зэрэгт төвлөрч, цар хүрээ нь эрс багасчээ.
- **Нидерланд:** ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний төв DLV Plant-ыг 1990-ээд онд хувьчилснаар мөн орон тоогоо цомхотгож, засгийн газрын буюу хувийн хэвшлийн гэрээт ажил гүйцэтгэх, ОУБ-уудын захиалгаар хөгжиж буй орнуудад төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх зэргээр үйл ажиллагаа нь хумигдсан байна. Одоо Нидерландын ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний гол гүйцэтгэгчид нь үйлдвэрлэлийн орц нийлүүлэгчид, борлуулагчид юм. Мөн фермерүүд өөрсдөө бүлгийн зохион байгуулалтад орж, гэрээгээр зөвлөх мэргэжилтэн авч ажиллуулах туршлага дэлгэрчээ.
- **Латин Америк:** Латин Америкийн ихэнхи орнууд ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээгээ хувийн хэвшилд хариуцуулах тогтолцоонд сүүлийн 20 жил шилжсэн боловч энэ тогтолцоо Чилээс бусад оронд үр дүнгүй нь нотлогдсон тул эргээд төрийн мэдлийн экстейншиний тогтолцоонд шилжиж байна. Коста Рика улс анхнаасаа нэвтрүүлэх үйлчилгээг хувьчлалгүй, төрийн мэдэлд авч үлдсэн нь эдүгээ үлгэр дуурайл болж байна.

4. Монгол улсад ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээг бэхжүүлэх санал, зөвлөмж



Зургийн эх сурвалж: Зохиогч



Дунд хугацааны стратегийн зорилтууд



Зургийн эх сурвалж: Зохиогч



Санал, зөвлөмж

1. Олон оролцогч бүхий плюралист тогтолцоог төлөвшүүлэх

- Технологи дамжуулах чиглэлээр ХААИС, ХАА-н ЭШХ-үүд голчлон ажиллах, аймгуудын ХХААГ-уудтай хамтран гүйцэтгэх, нэгдсэн зохицуулалт, холболтыг ХААҮШУОНТ хариуцах
- Зөвлөх үйлчилгээг ХАА-н хоршоо, ХААДС болон хувийн хэвшлийн байгууллагууд, орон нутгийн мал эмнэлгийн ба мал үржлийн нэгжүүд, хараат бус зөвлөхүүд хариуцах
- Идэвхижүүлэлт-Холболтыг сумдын ХАА-н мэргэжилтнүүд, багийн засаг дарга нар хариуцах
- Экстейншиний ажилтнууд, МЭҮТ-ийн ажилтнуудыг нэвтрүүлэх үйлчилгээний арга зүйн сургалтанд 4 жил тутамд хамруулах, сургалтыг ХААҮШУОНТ зохион байгуулах

Дунд хугацааны шалгуур үзүүлэлт:

- Нэвтрүүлэх үйлчилгээний нийт санхүүжилтийн 50 хувийг улс, орон нутгийн төсвөөс, 50 хувийг хувийн хэвшлээс гаргуулах.

Санал, зөвлөмж

2. Бодит үр дүн, практик үйл ажиллагаанд төвлөрөх

- ХААҮШОНТ-ийн загвар аж ахуйг шинэ технологийн инкубатор болгон хөгжүүлэх
- Аймаг бүрт сонгосон ААН-үүдийг жишиг аж ахуйнууд болгож, аймгийн Нэвтрүүлэх төвүүд (ХХАА-н Бизнес хөгжлийн төвүүд) хамтран ажиллах
- Сургалт, зөвлөгөө, технологи дамжуулах үйлчилгээг жишиг аж ахуйнуудыг түшиглэн бодит орчинд практик арга зүйгээр зохион байгуулах

Дунд хугацааны шалгуур үзүүлэлт:

- ХААҮШОНТ-ийн загвар аж ахуйг аж ахуйн тооцоонд ажиллах, жилд 2-3 шинэ технологи нэвтрүүлж сурталчлах чадавхитай болгох.
- Аймаг бүрт 2-3 жишиг аж ахуй бий болгох.

Хэтийн зорилт: Бүсийн төвшний Инновацийн төвүүд байгуулж, шинэ технологийн үзүүлэн сурталчилгааг тогтмол зохион байгуулах.

Санал, зөвлөмж

Орон нутагт жишиг аж ахуйнууд бий болгох



Санал, зөвлөмж

3. Санхүүгийн байнгын эх үүсвэртэй болгох

- Орон нутагт Хөдөлмөр, нийгмийн халамжийн хэлтсүүдээр дамжин хэрэгждэг мэргэжил олгох, чадавхижуулах хөтөлбөрүүдийг аймгийн ХХААГ-ууд хамтран хэрэгжүүлэх
- ХАА-н гаралтай бүтээгдэхүүний борлуулалтаас тодорхой хувийн (1-2%) шимтгэл авах, үүний 50%-ийг нэвтрүүлэх үйлчилгээнд зарцуулах

Дунд хугацааны шалгуур үзүүлэлт: Жил бүр тогтмол төрөөс тодорхой төсөв олгох замаар ХААҮШУОНТ болон аймгуудын Нэвтрүүлэх төвүүд (ХХАА-н бизнес хөгжлийн төвүүд)-ийн үйл ажиллагааг тогтворжуулах. Уг төсөв нь нэвтрүүлэх үйлчилгээний нийт санхүүжилтийн 20-30%-д дүйцэж байх.

Санал, зөвлөмж

4. Мэдээлэл, харилцааны технологи ашиглах

- Орон нутгийн ХАА-н мэргэжилтнүүд, сумдын болон багийн засаг дарга нарыг мэргэшүүлэх зайны сургалтыг интернэтээр явуулах, үүнийг ХААҮШУОНТ мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах
- ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд фэйсбүүк ашиглан мэдээлэл, зөвлөмж өгөх сүлжээг бий болгох, үүний нэгдсэн зохицуулалтыг ХААҮШУОНТ хариуцаж, аймгуудын ХХААГ-ууд хэрэгжүүлэх (үүнд олон улсын байгууллагуудыг татан оролцуулах)
- Нэвтрүүлэх үйлчилгээнд мэдээлэл, харилцааны технологи ашиглах бусад боломжуудыг судлах

Дунд хугацааны шалгуур үзүүлэлт:

- Зайны сургалтын хөтөлбөрт бүх сум, багийн засаг дарга нар, орон нутгийн бүх ХАА-н мэргэжилтнүүдийг жил бүр хамруулж байх
- Фэйсбүүк ашиглан зайнаас мэдээлэл, зөвлөмжөөр хангах үйл ажиллагаанд нийт малчдын 20-иос доошгүй хувийг, тариаланчдын 50-иас доошгүй хувийг хамруулах

Ашигласан эх сурвалж

- Alston, J.M, Marra, M.C., Pardey, P.G., Wyatt, T.J. (2000). A meta analysis of rates of return to agricultural R&D: *ex pede herucelem?* Washington, DC: International Food Policy Research Institute.
- Alston, J.M., Anderson, M.A., James, J.S., Pardey, P.G. (2011). The economic returns to U.S. public agricultural research. In: American Journal of Agricultural Economics, Vol. 93 (5), 2011, pp. 1257-1277.
- Birner, R. et al. (2006). From “Best Practice” to “Best Fit”: A framework for analyzing pluralistic agricultural advisory services worldwide. DSGD Discussion paper No. 37. Washington, DC: International Food Policy Research Institute.
- Department of Agriculture and Water Resources (DAWR), Australian Government. (2017). Data Tables: Rural research, development and extension in Australia. Unpublished.
- Cristoplos, I. (2010). Mobilizing the potential of rural and agricultural extension. Rome: Food and Agriculture Organization of the United Nations (FAO).
- Dercon, S., Gilligan, D.O., Hoddinott, J., Woldehanna, T. (2008). The impact of agricultural extension and roads on poverty and consumption growth in fifteen Ethiopian villages. IFPRI Discussion paper. Washington, DC: International Food Policy Research Institute.
- Huffman, W.E., Evenson, R.E. (2006). Science for Agriculture: A long-term perspective. 2nd edition. Oxford: Blackwell publishing.
- Kaegi, S. (2015). The experiences of China’s agricultural system in reaching a large number of farmers with rural advisory services. Background paper to the SDC face-to-face workshop „Reaching the millions!“ in Hanoi, March 2015.
- Katz, E. (2002). Innovative approaches to financing extension for agriculture and natural resource management. Conceptual considerations and analysis of experience. Lindau: Swiss Center for Agricultural Extension.
- Katz, E. (2003). The Extension Butterfly. A model to illustrate the functions of extension in the context of rural development. Lindau: Swiss Center for Agricultural Extension.
- Swanson, B.E., Rajalahti, R. (2010). Strengthening agricultural extension and advisory systems: Procedures for assessing, transforming, and evaluating extension systems. Agriculture and Rural Development Discussion paper No. 45. Washington, DC: The World Bank.
- Эрдэнэболор, Б. (2017). Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх үйлчилгээний олон улсын туршлага, эдийн засагт үзүүлэх нөлөө. “Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, технологи, инноваци - 2017” зөвлөлдөх уулзалтад тавьсан илтгэл. Улаанбаатар: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам.